



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Цэцэрлэг сумын хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2026/030/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.open.audit.mn

Архангай аймаг
2026 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа

Утас: 7033-3141

Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер Д.Нэргүйбаатар

Утас: 7033-2860

Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn

Аудит гүйцэтгэсэн: Шинжлэн магадлахуй ЭЗШ аудит
ХХК

Утас: 99197346, 77665858

Цахим хаяг: Info@shinjenmagadlakhui-audit.mn

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2026-02-25 № 144
танай _____-ны № _____-т

АРХАНГАЙ АЙМГИЙН ЦЭЦЭРЛЭГ
СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Б.ДАДЬМАА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Архангай аймгийн Цэцэрлэг сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудал

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд 9 арга	хэмжээг	“Сургуулийн өмнөх боловсрол” хэрэгжүүлэхээр 1,205,912.5 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 1,145,766.4 мянган төгрөгийг зарцуулсан байна.
--	---------	---

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 үндсэн зорилтын хүрээнд 14 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	291,198,982.27	128,374,976.72
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	194,014,902.27	36,640,477.72
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	194,014,902.27	36,640,477.72
3121	Төгрөг	194,014,902.27	36,640,477.72
31211	Төрийн сангийн харилцах	194,014,902.27	36,640,477.72
35	БАРАА МАТЕРИАЛ	97,184,080.00	91,734,499.00
351	Түүхий эд материал	2,175,000.00	2,175,000.00
35130	Эм боох материал	2,175,000.00	2,175,000.00
354	Хангамжийн материал	95,009,080.00	89,559,499.00
35410	Бичиг хэргийн материал	2,538,000.00	4,079,400.00
35420	Аж ахуйн материал	92,471,080.00	85,480,099.00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	751,404,927.64	780,365,739.64
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	751,404,927.64	780,365,739.64
392	Биет хөрөнгө	742,196,607.83	771,186,629.87
39201	Барилга, байгууламж, орон сууц	706,688,318.00	706,688,318.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(33,824,674.62)	(45,602,813.22)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	48,299,928.00	55,028,273.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(14,915,591.49)	(20,881,781.17)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	45,072,826.92	85,342,601.92
39208	Хуримтлагдсан элэгдэл	(17,287,507.17)	(24,631,776.81)
39214	Бусад үндсэн хөрөнгө	21,390,000.00	30,190,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(14,620,791.81)	(16,340,291.85)
39217	Ном	1,394,100.00	1,394,100.00
393	Биет бус хөрөнгө	9,208,319.81	9,179,109.77
39301	Програм хангамж	292,100.00	292,100.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(251,780.19)	(280,990.23)
39303	Бусад биет бус хөрөнгө	9,168,000.00	9,168,000.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,042,603,909.91	908,740,716.36
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,042,603,909.91	908,740,716.36
51	Засгийн газрын хувь оролцоо	1,042,603,909.91	908,740,716.36
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	440,099,128.00	440,099,128.00
51101	Өмч: - төрийн	440,099,128.00	440,099,128.00
512	Хуримтлагдсан үр дүн	602,504,781.91	468,641,588.36
51210	Өмнөх үеийн үр дүн	602,504,781.91	602,504,781.91
51220	Тайлант үеийн үр дүн	-	(133,863,193.55)
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,042,603,909.91	908,740,716.36

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	936,920,658.00	1,044,100,120.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	21,467,058.00	46,853,920.00
120	Нийтлэг татварын бус орлого	21,467,058.00	46,853,920.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	21,292,058.00	140,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	140,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	21,292,058.00	39,766,120.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал		6,947,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	915,453,600.00	997,246,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	881,153,600.00	939,916,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	881,153,600.00	939,916,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	34,300,000.00	57,330,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	34,300,000.00	57,330,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	848,585,815.63	1,177,963,313.55
21	УРСГАЛ ЗАРДАЛ	848,585,815.63	1,177,963,313.55
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	845,227,877.73	1,168,969,107.19
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	604,263,302.18	856,667,175.27
210101	Үндсэн цалин	415,458,589.88	525,973,904.36
210102	Нэмэгдэл	160,848,622.30	285,823,440.91
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	3,410,000.00
210104	Урамшуулал	27,956,090.00	41,459,830.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	76,051,073.25	99,709,099.28
210201	Тэтгэврийн даатгал	51,171,249.67	67,809,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,136,517.03	7,978,199.28
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,433,853.07	3,990,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,298,206.34	3,990,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12,011,247.14	15,940,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,617,062.10	28,475,793.64
210301	Гэрэл, цахилгаан	6,959,538.10	9,661,088.64
210302	Түлш, халаалт	18,625,524.00	18,614,705.00
210303	Цэвэр, бохир ус	32,000.00	200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	24,196,681.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	3,008,300.00
210408	Бараа материал акталсны зардал	-	21,188,381.00
2105	Нормативт зардал	85,152,150.00	88,467,000.00
210502	Хоол, хүнс	85,152,150.00	88,467,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,500,000.00	20,000,000.00
210604	Урсгал засвар	5,500,000.00	20,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,911,000.00	2,160,770.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,911,000.00	2,160,770.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	46,733,290.20	49,292,588.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,460,218.00	16,659,880.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,635,900.00	5,795,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	16,637,172.20	26,837,308.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,357,937.90	8,994,206.36
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,357,937.90	8,994,206.36

213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,357,937.90	8,994,206.36
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	88,334,842.37	(133,863,193.55)
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	88,334,842.37	(133,863,193.55)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	915,628,600.00	997,386,200.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	175,000.00	140,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	175,000.00	140,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	175,000.00	140,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	140,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	915,453,600.00	997,246,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	881,153,600.00	939,916,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	881,153,600.00	939,916,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	34,300,000.00	57,330,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	34,300,000.00	57,330,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	834,573,625.43	1,138,728,624.55
21	УРСГАЛ ЗАРДАЛ	834,573,625.43	1,138,728,624.55
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	831,215,687.53	1,129,734,418.19
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	604,263,302.18	856,667,175.27
210101	Үндсэн цалин	415,458,589.88	525,973,904.36
210102	Нэмэгдэл	160,848,622.30	285,823,440.91
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	3,410,000.00
210104	Урамшуулал	27,956,090.00	41,459,830.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	76,051,073.25	99,709,099.28
210201	Тэтгэврийн даатгал	51,171,249.67	67,809,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,136,517.03	7,978,199.28
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,433,853.07	3,990,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,298,206.34	3,990,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12,011,247.14	15,940,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,617,062.10	28,475,793.64
210301	Гэрэл, цахилгаан	6,959,538.10	9,661,088.64
210302	Түлш, халаалт	18,625,524.00	18,614,705.00
210303	Цэвэр, бохир ус	32,000.00	200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	-
2105	Нормативт зардал	84,724,650.00	88,467,000.00
210502	Хоол, хүнс	84,724,650.00	88,467,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,500,000.00	20,000,000.00
210604	Урсгал засвар	5,500,000.00	20,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,911,000.00	2,160,770.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,911,000.00	2,160,770.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33,148,600.00	34,254,580.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	26,202,700.00	27,186,780.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,945,900.00	7,067,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,357,937.90	8,994,206.36
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,357,937.90	8,994,206.36

213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,357,937.90	8,994,206.36
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	81,054,974.57	(141,342,424.55)
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	400,000.00	16,032,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	400,000.00	16,032,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	400,000.00	16,032,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	400,000.00	16,032,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(400,000.00)	(16,032,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	80,654,974.57	(157,374,424.55)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		194,014,902.27
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	194,014,902.27	36,640,477.72

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	440,099,128.00	-	602,504,781.91	1,042,603,909.91
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	440,099,128.00	-	602,504,781.91	1,042,603,909.91
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	440,099,128.00	-	602,504,781.91	1,042,603,909.91
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(133,863,193.55)	(133,863,193.55)
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	440,099,128.00	-	468,641,588.36	908,740,716.36

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Хувь
1	ТАТААС, САНХҮҮЖИЛТЫН ОРЛОГО	1,029,130,800.00	988,251,993.64	40,878,806.36	96.03
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	971,800,800.00	939,916,200.00	31,884,600.00	96.72
131001	Улсын төсвөөс санхүүжих	971,800,800.00	939,916,200.00	31,884,600.00	96.72
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	57,330,000.00	48,335,793.64	8,994,206.36	84.31
132001	Орон нутгийн төсвөөс	57,330,000.00	48,335,793.64	8,994,206.36	84.31
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	176,781,600.00	140,000.00	176,641,600.00	0.08
1E+06	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		140,000.00	-140,000.00	
1E+06	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	176,781,600.00		176,781,600.00	
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,205,912,400.00	988,391,993.64	217,520,406.36	81.96
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,205,912,400.00	1,145,766,418.19	60,145,981.81	95.01

Архангай аймгийн Цэцэрлэг сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,205,912,400.00	1,145,766,418.19	60,145,981.81	95.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	865,281,300.00	856,667,175.27	8,614,124.73	99
210101	Үндсэн цалин	542,867,100.00	525,973,904.36	16,893,195.64	96.89
210102	Нэмэгдэл	301,888,300.00	285,823,440.91	16,064,859.09	94.68
210103	Унаа хоолны хөнгөлөлт		3,410,000.00	-3,410,000.00	
210104	Урамшуулал	20,525,900.00	41,459,830.00	-20,933,930.00	202
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	107,554,100.00	99,709,099.28	7,845,000.72	92.71
210201	Тэтгэврийн даатгал	72,943,100.00	67,809,200.00	5,133,900.00	92.96
210202	Тэтгэмжийн даатгал	8,652,800.00	7,978,199.28	674,600.72	92.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,326,300.00	3,990,500.00	335,800.00	92.24
210204	Ажилгүйдлийн даатгал	4,326,300.00	3,990,500.00	335,800.00	92.24
210205	Эрүүл мэндийн даатгал	17,305,600.00	15,940,700.00	1,364,900.00	92.11
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,330,000.00	28,475,793.64	8,854,206.36	76.28
210301	Гэрэл, цахилгаан	11,180,000.00	9,661,088.64	1,518,911.36	86.41
210302	Түлш, халаалт	24,950,000.00	18,614,705.00	6,335,295.00	74.61
210303	Цэвэр, бохир ус	1,200,000.00	200,000.00	1,000,000.00	16.67
2104	Хангамж, бараа материалын зардал				
2105	Нормативт зардал	92,344,800.00	88,467,000.00	3,877,800.00	95.8
210502	Хоол, хүнс	92,344,800.00	88,467,000.00	3,877,800.00	95.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,000,000.00	20,000,000.00		100
210604	Урсгал засвар	20,000,000.00	20,000,000.00		100
2107	Томилолт, зочны зардал				
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,130,800.00	3,192,770.00	938,030.00	77.29
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,130,800.00	3,192,770.00	938,030.00	77.29
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	79,271,400.00	49,254,580.00	30,016,820.00	62.13
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	72,203,600.00	42,186,780.00	30,016,820.00	58.43
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,067,800.00	7,067,800.00		100
2	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	1,205,912,400.00	1,145,766,418.19	60,145,981.81	95.01
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		194,014,902.27	194,014,902.27	-
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		36,640,477.72	-36,640,477.72	

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа¹ илрээгүй, залруулаагүй 10,861.9 мянган төгрөгийн зөрчил² илэрч 2 албан шаардлага хүргүүлээ.

Аудитаар залруулагдаагүй 2 зөрчилтэй асуудлын материаллаг зөрчил нь 10,861.9 мянган төгрөг бөгөөд гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 13,252.09 мянган төгрөгөөс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

3.1 Албан шаардлага

3.1.1. Тайлант онд төсвийн хөрөнгөөр бараа материалын худалдан авалтыг цахим дэлгүүрээс аваагүй, бусад этгээдээс 4,510,300 төгрөгийн худалдан авсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-т "Улс, орон нутгийн төсөв болон захиалагчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад энэ хуулийг дагаж мөрдөнө", 4 дүгээр зүйлийн 4.1.8-д "ерөнхий гэрээний арга" гэж захиалагчийн тодорхой хугацаанд давтамжтай худалдан авдаг, эсхүл байнгын хэрэгцээтэй бараа, үйлчилгээний нэгж дээд үнэ болон бусад нөхцөлийг тогтоосон ерөнхий гэрээг нэг ба түүнээс дээш оролцогчтой байгуулж, цахим дэлгүүрээс бараа, үйлчилгээ худалдан авахыг"; 9 дүгээр зүйлийн 9.1-т "Хуульд өөрөөр заагаагүй бол худалдан авах ажиллагааг зохион байгуулах, мэдээлэл солилцох, мэдээллийн ил тод байдлыг хангах ажиллагааг цахим системээр гүйцэтгэнэ", 38 дугаар зүйлийн 38.1-т "Ерөнхий гэрээний аргын хоёрдугаар үе шатанд захиалагч худалдан авах бараа, үйлчилгээний тоо хэмжээ, хүргэх газар, хуваарь бүхий захиалгын хуудсыг цахим системд илгээж, үнийн санал дуудаж цахим дэлгүүрээс худалдан авна" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

3.1.2 Тайлант оны 11 сард байгууллагын нийт алба хаагчдад ур чадварын нэмэгдлийг хавтгайруулан 6,351,592.78 төгрөгийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Боловсрол шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр нийгэм хамгааллын сайдын 2021 оны А/36/А10/9 дугаартай хамтарсан тушаалын 7 шалгуур үзүүлэлтийн үнэлгээгээр 60.0 болон түүнээс дээш хувийг хангасан багш ажилтанд тухайн жилийн батлагдсан төсөвт багтаан ур чадварын нэмэгдэл олгоно. 12-д Ур чадварын нэмэгдлийг тухайн багш ажилчдын манлайлал, мэргэжлийн ур чадвараас өөр хүчин зүйл(эрүүл мэнд, амьдрал, ахуйн нөхцөл, байдлыг) харгалзан олгохыг хориглоно. гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Цахим худалдан авалттай холбоотой	1	4,510.3			1	4,510.3						
Цалин, урамшуулалтай холбоотой	1	6,351.6			1	6,351.6						
Дүн	2	10,861.9			2	10,861.9						